



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/79

Баян-Адарга сум

**Хог хаягдал түр хадгалах цэг
тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дахь заалт, Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хэнтий аймгийн Баян-Адарга сумын төвийн Дуурлиг багийн нутаг дэвсгэрт хамаарах 2.82 км авто замын байгууламжийн ажлыг хариуцагч 64055824 регистрийн дугаартай Их хайрхны харгуй ХХК нь Дуурлиг багийн нутагт байрлах түр кемпийн хог хаягдал түр хадгалах цэгийн тогтоосугай.

2. Хог хаягдал түр хадгалах цэгийн байршлын зураг, солбилцолыг хавсралт ёсоор баталсугай.

3. Дээрх газарт үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэлгүй холбогдох хууль тогтоомж болон байгаль орчин менежментийн төлөвлөгөөг мөрдөн ажиллаж, сумын байгаль хамгаалагчтай хог хаягдлын гэрээ байгуулж Их хайрхны харгуй ХХК-д даалгасугай.


4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дуурлиг багийн Засаг дарга (М.Нямдорж) Байгаль хамгаалагч (О.Батсуурь) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.ЛХАГВАДОРЖ

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Засаг
даргын 2025 оны 08 дугаар сарын 15 ны
өдрийн А/79 тоот захирамжийн хавсралт



Хог хаягдал түр хадгалах цэгийн солбицол, байршлын зураг

№	Газрын зориулалт	Солбицол		Талбайн хэмжээ
		N	E	
1	Хог хаягдал түр хадгалах цэг	48.558689	111.11384	5га